

**ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС  
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ  
ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

БАЯН-ӨЛГИЙ

2009 ОН

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Гэрээний үндсэн үзүүлэлтийн тоо	Үүнээс хэрэгжсэн үзүүлэлтийн тоо	Тасалдсан буюу дутуу биелэгдсэн	Хэрэгжилтийн хувь	Үнэлгээ	Тасалдсан буюу дутуу биелэгдсэн үзүүлэлт, түүний шалтгаан
1	Монгол улсын шадар сайд	38	36	2	94,7	A	Хүүхдэд зориулсан үйлчилгээг өргөтгөх заалтын хүрээнд аймгийн хүүхдийн ордон барихаар төлөвлөж байгаа боловч хөрөнгийн эх үүсвэргүйгээс хойшлогдсон. Гамшгийн нөөцөд малын өвс, тэжээлээс бусад нөөц бүрдүүлж чадаагүй
2	Хууль зүй, дотоод хэргийн сайд	33	29	4	87,8	B	Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймаг, сумын санд хөрөнгө хуримтлагдаагүй, Баяннуур суманд цагдаагийн кабон барихаар төлөвлөсөн боловч санхүүгийн эх үүсвэр хүрэлцээгүй учир баригдаагүй, хууль сурталчлах, ГХУС арга хэмжээний зардлыг нэмэгдүүлж чадаагүй байна.
3	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	14	13	1	94,5	A	Соёлын байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх талаар тавьсан зорилтууд санхүүгийн эх үүсвэр хүрэлцээгүйгээс биелэгдээгүй. Тухайлбал ХД театрын үзэгчдийн сандлыг шинэчлэх, аймгийн номын сангийн барилга барих ажил хийгдээгүй.
4	Батлан хамгаалахын сайд	17	16	1	94,1	A	Санхүүгийн эх үүсвэр хүрэлцээгүйгээс аймгийн ЗДТГ-ын цэргийн штабт сургалт, иргэний хамгаалалтын төлөвлөлт хариуцсан ажилтан авч ажиллуулаагүй.
5	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн	36	33	3	91,6	A	Орон нутагт махны нөөц сан бүрдүүлэх, цөцгийн тосны үйлдвэрлэлийг сэргээж байгуулах. Отрын бүс нутаг байгуулах

	сайд						зорилтууд хэрэгжээгүй, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, сум тус бүрт агропарк байгуулах ажил төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй.
6	Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайд	9	8	1	88,8	В	Өлгий хотын доторх хатуу хучилттай замыг шинэчлэх ажил оройтож эхэлснээс хугацаандаа дуусаагүй.
7	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	45	43	2	95,5	А	Гэрээгээр хүлээсэн үүргээс сайн дурын даатгалд хамрагсдын тоог нэмэгдүүлэх заалт 65 хувиар тасалдсан. Мөн хүн амын бүлгийн хөгжлийг дэмжих, бодлого, хөтөлбөр боловсруулаагүй
8	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	20	20		100%	А	
9	Эрүүл мэндийн сайд	23	21	2	91,3	А	0-1 насны хүүхдийн эндэгдэл 2008 онд 16 байсан бол 2009 онд 68 болж нэмэгдсэн, эхийн эндэгдэл 2008 онд 2 байсан бол 2009 онд 5 болж нэмэгдснээс гэрээний үүрэг биелэгдээгүй.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ**